

# “СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04-р сарын 21-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

## 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн №02 тоот “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.СОЁЛ-ЭРДЭНЭ

# “СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04-р сарын 21-ний өдөр

№ 02

Улаанбаатар хот

## ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ ЧӨЛӨӨЛЖ, ТОМИЛОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар бүлэг болон “Сүү” ХК-ийн 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн № 02 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгосугай.

2. “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ердийн гишүүнээр:

1. Д.Ганбаатар
2. Д.Цэрэнжигмэд
3. Д.Тунгалаг
4. Д.Уянгалянхуа
5. С.Сүхболд
6. С.Отгонжаргал
7. Д.Жамъян
8. Б.Түвшинтөгс

Хараат бус гишүүнээр:

9. Н.Цэрэндорж
10. Г.Баяр
11. Б.Батзориг
12. Д.Давааням

ХУРЛЫН ДАРГА



Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ

# “СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04-р сарын 21-ний өдөр

№ 03

Улаанбаатар хот

## ТУЗ-ИЙН ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар бүлэг болон “Сүү” ХК-ийн 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн № 02 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин, урамшууллын хэмжээг дараах байдлаар тогтоож, 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн, сар тутамд тооцон олгосугай. Үүнд:

№	Албан тушаал	Тухайн жилд олгох цалин, урамшууллын нийт хэмжээ
1.	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга болон гишүүд	Компанийн жилийн цалингийн зардлын төлөвлөгөөний 2.8%

2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин, урамшууллыг тогтоосон хэмжээгээр, олгохыг Гүйцэтгэх захирал /М.Болод/-д тус тус зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ